



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2016 оны 01 сарын 13 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийг тус тус үндэслэн Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хорооноос ТОГТООХ нь:

Нэг. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 2015 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Авлигатай тэмцэх, хариуцлага, шударга ёсыг бэхжүүлэх үндэсний хөтөлбөр батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Х.Тэмүүжин

-Улсын Их Хурлын гишүүн

Гишүүд:

З.Баянсэлэнгэ

-Улсын Их Хурлын гишүүн

Л.Болд

-Улсын Их Хурлын гишүүн

С.Дэмбэрэл

-Улсын Их Хурлын гишүүн

Д.Лүндээжанцан

-Улсын Их Хурлын гишүүн

Ц.Оюунгэрэл

-Улсын Их Хурлын гишүүн

Хоёр. Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, судалгаа хийх ажлын дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

1.Ч.Өнөрбаяр

-Монгол Улсын Ерөнхийлөгчийн Хүний эрх, хуулийн бодлогын зөвлөх

2.Б.Бат-Отгон

-Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн дарга

3.Н.Анхбаяр

-Гадаад хэргийн яамны Хүний эрхийн хэлтсийн дарга

4.Ж.Сарангэрэл

-Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан

5.Ц.Ариунжаргал

-Хууль зүйн яамны Эрх зүйн шинэчлэлийн

бодлогын газрын ахлах мэргэжилтэн

6.Л.Төр-Од

-Авлигатай тэмцэх газрын дэргэдэх олон нийтийн зөвлөлийн дарга

7.Б.Долгор

-Монголын хуульч эмэгтэйчүүдийн холбооны тэргүүн

8. Б.Баасандорж

-Хууль зүйн байнгын хорооны ахлах зөвлөх

9.Ч.Ариунхур

-Төрийн байгуулалтын байнгын хорооны ахлах зөвлөх

10.Б.Хонгорзул

-Хууль зүйн байнгын хорооны зөвлөх

11.М.Элбэгдорж

-Төрийн байгуулалтын байнгын хорооны зөвлөх

12.Ч.Батбямба

-Хууль зүйн байнгын хорооны референт

13.Б.Төрболд

-Төрийн байгуулалтын байнгын хорооны референт

